



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Арвайхээр сумын Нарны дөш ӨЭМТөвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨВА-2022/1/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал
Утас: 70323253 Цахим хаяг: batjargalo@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Гансүх
Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com
Аудитор: Ц.Чанцалдиймаа
Утас: 99710673 Цахим хаяг: chantsal1227 @ yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Төлбөрийн акт.....	13
4.3 Албан шаардлага.....	14
4.4 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

АРВАЙХЭЭР СУМЫН НАРНЫ ДӨШ
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ё.ШҮРЭНЦЭЦЭГ ТАНАА

Ауд. 02. 08 № 265
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 -д заасны дагуу Арвайхээр сумын Нарны дөш өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арвайхээр сумын Нарны дөш өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хөрөглөгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

015030530

D:\Auditin gazar\baiguullaglin dotood barimt\A4

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,491,131.30</u>	<u>104,363,008.15</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	251,551.30	98,776.25
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	251,551.30	98,776.25
3121	Төгрөг	251,551.30	98,776.25
31211	Төрийн сангийн харилцах	251,551.30	98,776.25
33	АВЛАГА	12,600.00	100,781,536.45
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	12,600.00	1,702,458.45
335	Бусад авлага	-	99,079,078.00
3351	Байгууллагаас авах авлага	-	99,079,078.00
35	БАРАА МАТЕРИАЛ	10,226,980.00	3,482,695.45
351	Түүхий эд материал	7,424,530.00	2,165,100.00
35130	Эм боох материал	7,424,530.00	2,165,100.00
354	Хангамжийн материал	2,802,450.00	1,317,595.45
35410	Бичиг хэргийн материал	1,373,250.00	-
35420	Аж ахуйн материал	730,000.00	1,317,595.45
35470	Бусад хангамжийн материал	699,200.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>377,451,730.10</u>	<u>399,294,720.48</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	377,451,730.10	399,294,720.48
392	Биет хөрөнгө	334,063,896.52	356,094,720.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	310,771,406.60	310,771,406.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(27,689,172.46)	(37,123,791.70)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,916,668.00	21,916,668.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(10,574,758.84)	(12,941,666.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	65,995,862.52	100,918,370.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	(36,203,218.28)	(40,538,899.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,183,193.77	28,702,093.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,336,084.79)	(15,609,459.80)
393	Биет бус хөрөнгө	43,387,833.58	43,200,000.00
39301	Програм хангамж	490,000.00	490,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(302,166.42)	(490,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	43,200,000.00	43,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>387,942,861.40</u>	<u>503,657,728.63</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,348,024.60</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,348,024.60	-
413	Өглөг	4,348,024.60	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,348,024.60	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>383,594,836.80</u>	<u>503,657,728.63</u>

51	Засгийн газрын хувь оролцоо	383,594,836.80	503,657,728.63
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	112,218,568.00	112,218,568.00
51101	Өмч: - төрийн	112,218,568.00	112,218,568.00
512	Хуримтлагдсан үр дүн	221,487,779.22	341,550,671.05
51210	Өмнөх үеийн үр дүн	221,487,779.22	221,487,779.22
51220	Тайлант үеийн үр дүн	-	120,062,891.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	49,888,489.58	49,888,489.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	387,942,861.40	503,657,728.63

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	342,715,220.00	1,208,748,309.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	430,731,064.76
120	Нийтлэг татварын бус орлого	-	430,731,064.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	430,731,064.76
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,881,932.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	428,849,132.76
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	342,715,220.00	778,017,245.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	339,260,500.00	431,260,184.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	339,260,500.00	431,260,184.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,454,720.00	43,311,140.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,044,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,454,720.00	36,266,640.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	303,445,921.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	303,445,921.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	347,516,697.62	1,088,685,417.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	347,516,697.62	1,088,685,417.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	326,476,697.62	1,026,342,917.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,583,886.00	214,271,655.00

210101	Үндсэн цалин	221,583,886.00	214,271,655.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,735,965.00	34,053,479.00
210201	Тэтгэврийн даатгал	14,107,841.00	11,076,720.00
210202	Тэтгэмжийн даатгал	525,625.00	9,000,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	657,031.00	3,000,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	131,406.00	3,800,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,314,062.00	7,176,459.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,387,012.00	19,197,770.00
210301	Гэрэл, цахилгаан	3,099,982.00	2,690,369.00
210302	Түлш, халаалт	11,524,740.00	16,507,401.00
210303	Цэвэр, бохир ус	762,290.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	25,472,360.00	26,873,492.75
210401	Бичиг хэрэг	6,218,920.00	6,974,500.00
210402	Тээвэр, шатахуун	4,337,490.00	5,196,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	165,050.00	2,282,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	80,000.00	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,670,900.00	11,939,642.75
2105	Нормативт зардал	25,746,649.00	622,978,504.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,728,349.00	616,346,404.00
210502	Хоол, хүнс	1,018,300.00	433,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	6,198,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	8,442,650.00
210604	Урсгал засвар	-	8,442,650.00
2107	Томилолт, зочны зардал	1,429,000.00	1,402,238.00
210702	Дотоод албан томилолт	1,429,000.00	1,402,238.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,269,098.00	79,524,712.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,532,100.00	79,114,884.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-

210803	Даатгалын үйлчилгээ	-	49,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	229,198.00	75,728.00
210807	Газрын төлбөр	183,800.00	284,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,852,727.62	19,598,417.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
2132	Бусад урсгал шилжүүлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,040,000.00	62,342,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(4,801,477.62)	120,062,891.83
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(4,801,477.62)	120,062,891.83

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	112,218,568.00	49,888,489.58	221,487,779.22	0.00	383,594,836.80
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	112,218,568.00	49,888,489.58	221,487,779.22	0.00	383,594,836.80
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	112,218,568.00	49,888,489.58	221,487,779.22	0.00	383,594,836.80
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	112,218,568.00	49,888,489.58	221,487,779.22	0.00	383,594,836.80
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	112,218,568.00	49,888,489.58	221,487,779.22	0.00	383,594,836.80
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	120,062,891.83	0.00	120,062,891.83
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	112,218,568.00	49,888,489.58	341,550,671.05	0.00	503,657,728.63

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	342,715,220.00	779,899,177.00

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,881,932.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,881,932.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,881,932.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,881,932.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	342,715,220.00	778,017,245.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	339,260,500.00	431,260,184.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	339,260,500.00	431,260,184.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,454,720.00	43,311,140.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,044,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,454,720.00	36,266,640.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	303,445,921.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	303,445,921.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	327,627,145.40	762,209,352.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	327,627,145.40	762,209,352.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,587,145.40	700,564,352.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,434,773.40	324,890,916.05
210101	Үндсэн цалин	217,434,773.40	324,890,916.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,735,965.00	34,053,479.00
210201	Тэтгэврийн даатгал	14,107,841.00	11,076,720.00
210202	Тэтгэмжийн даатгал	525,625.00	9,000,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	657,031.00	3,000,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	131,406.00	3,800,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,314,062.00	7,176,459.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,387,012.00	19,197,770.00
210301	Гэрэл, цахилгаан	3,099,982.00	2,690,369.00
210302	Түлш, халаалт	11,524,740.00	16,507,401.00
210303	Цэвэр, бохир ус	762,290.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	22,750,560.00	26,338,800.00
210401	Бичиг хэрэг	7,388,320.00	4,986,250.00
210402	Тээвэр, шатахуун	4,337,490.00	5,196,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	165,050.00	2,282,650.00
210404	Ном, хэвлэл	305,100.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	80,000.00	480,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,474,600.00	13,393,200.00
2105	Нормативт зардал	30,580,737.00	207,935,987.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,185,037.00	196,483,887.00
210502	Хоол, хүнс	1,018,300.00	379,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,377,400.00	11,072,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	7,220,450.00
210602	Тавилга	-	100,000.00
210604	Урсгал засвар	-	7,120,450.00
2107	Томилолт, зочны зардал	1,429,000.00	1,402,238.00
210702	Дотоод албан томилолт	1,429,000.00	1,402,238.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,269,098.00	79,524,712.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,532,100.00	79,114,884.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	49,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	229,198.00	75,728.00
210807	Газрын төлбөр	183,800.00	284,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,040,000.00	61,645,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,040,000.00	61,645,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,040,000.00	61,645,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,088,074.60	17,689,824.95
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,854,300.00	17,842,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,854,300.00	17,842,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,854,300.00	17,842,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,854,300.00	17,842,600.00
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(14,854,300.00)	(17,842,600.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	233,774.60	(152,775.05)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	251,551.30
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	233,774.60	98,776.25

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	426,789,680.00	780,051,952.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	426,789,680.00	780,051,952.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	398,544,680.00	718,406,952.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,147,320.00	324,890,916.05
210101	Үндсэн цалин	255,147,320.00	324,890,916.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,877,020.00	34,053,479.00
210201	Тэтгэврийн даатгал	11,076,720.00	11,076,720.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,000,300.00	9,000,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,000,000.00	3,000,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,800,000.00	3,800,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	7,176,459.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,875,920.00	19,197,770.00
210301	Гэрэл, цахилгаан	2,034,310.00	2,690,369.00
210302	Түлш, халаалт	9,841,610.00	16,507,401.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,443,400.00	26,338,800.00
210401	Бичиг хэрэг	2,538,750.00	4,986,250.00
210402	Тээвэр, шатахуун	4,424,700.00	5,196,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	362,650.00	2,282,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,877,300.00	13,393,200.00
2105	Нормативт зардал	79,609,620.00	207,935,987.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,781,520.00	196,483,887.00
210502	Хоол, хүнс	379,600.00	379,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,448,500.00	11,072,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,146,750.00	25,063,050.00
210602	Тавилга	4,937,600.00	17,942,600.00
210604	Урсгал засвар	2,209,150.00	7,120,450.00
2107	Томилолт, зочны зардал	1,402,230.00	1,402,238.00
210702	Дотоод албан томилолт	1,402,230.00	1,402,238.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,042,420.00	79,524,712.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,682,100.00	79,114,884.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	49,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	75,720.00	75,728.00
210807	Газрын төлбөр	284,600.00	284,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,245,000.00	61,645,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,245,000.00	61,645,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,245,000.00	61,645,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	251,551.30
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	98,776.25

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн тайлан ирүүлээгүй.

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Арвайхээр сумын Нарны дөш ӨЭМТөвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Чанцалдиймаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2022,02,06-ны өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллагын зорилго: Хүн амд нийгмийн эрүүл мэндийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй тасралтгүй хүргэж амьдралын түвшинг нэмэгдүүлэхэд оршино

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь ММНББИ, Эрүүл мэндийн яамны хамтран гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг мөрдөж байна.

Эрүүл мэндийн төвийн бүтцэд дотоод хяналтын орон тооны алба байхгүй. Дотоод хяналтын нэгж байхгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Арвайхээр сумын Нарны дөш ӨЭМТөвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлын үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 1088.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 16.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын хувьд тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 9.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж 5.9 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан байна. Бараа материалын хувьд өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус газар нь өөрийн орлого байхгүй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан 779.9 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Санхүүжилт өмнөх оноос 2.7 дахин өссөн байна. Энэ цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал өссөнтэй холбоотой юм.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1208.7 сая төгрөгөөр санхүүжигдэн, 1088.7 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээрх төсвийн тухай хуулийн дагуу нэмэлт санхүүжилтийн 43.3 сая төгрөгийн гүйцэтгэлийн тайланг гаргаж ирүүлээгүй зөрчил илэрлээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Тайланд онд хөрөнгө зарцуулах, тэтгэмжийн шийдвэрүүдийн хувьд үндэслэл зөрүүтэй, хүчингүй болсон дүрэм, журмыг үндэслэдэг зэрэг дотоод хяналт сул байдалтай холбоотой гарсан зөрчлүүд нь аудитын хувьд гол онцлох асуудал байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Арвайхээр сумын Нарны дөш ӨЭМТөв нь 2021 онд 151 мэдээлэл шилэн дансанд байршуулахаас 92 мэдээллийг хугацаандаа байршуулсан, 2 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй, 50 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Зайлшгүй оруулах шаардлагатай 7 мэдээлэл огт оруулаагүй байна. Нийт мэдээллийн 61.7 хувийг хугацаандаа 38.2 хувийг хугацаа хоцроосон байна.

1.Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр,Хагас жилээр,Улирал бүр,Сар бүр) 1, 2 дугаар сарын

төлөвлөгөө гүйцэтгэл мэдээлээгүй, мөн 11,12 дугаар сарын мэдээлэл болон 4 дүгээр улирал бүтэн жилийн төсвийн гүйцэтгэлийг огт байршуулаагүй байна.

2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр) :

5/25/2021 6,444,000 төгрөг ковид- 19 вакцинжуулалт

7/5/2021 8,779,950 төгрөг ковид -19 вакцинжуулалт

9/22/2021 13,000,000 төгрөг ковид -19 вакцинжуулалт

11/2/2021 7,500,000 төгрөг том хүний ковидын багц

11/10/2021 24,000,000 төгрөг мөнгөн тэтгэмж

12/7/2021 50,187,500 төгрөг тушаалаар дамжсан гүйлгээ

12/7/2021 9,400,000 төгрөг мөнгөн тэтгэмж

12/22/2021 25,812,184 төгрөгийн гүйлгээнүүд, бүгд 145.1 сая төгрөгийн гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байна.

3. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр):

Ашид буян ХХК 7779500 төгрөг, Оргих оргил ХХК 5208900 төгрөг, ӨВ Монос ЭХНТөв2 15249202.25 төгрөг, ӨВ Эм хангамж ХХК 18545766 төгрөг, Эм гоо 120297300 төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, ковид 19, том хүний ковидын багц, гэр эмчилгээ зэрэгт шилжүүлсэн бүгд 167.1 сая төгрөгийн гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хуулийн 54 дугаар зүйлийн 54.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.2 дах заалтуудад тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж биелэлтийг 2021 оны 05 сарын 28-ны өдрийн 14 тоотор хариуг хүргүүлсэн. Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлтийн биелэлт 100 хувь байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

4. Аудитын илрүүлэлт

1. Шилэн дансанд 13 удаагийн гүйлгээгээр 312.2 сая төгрөгийг байршуулаагүй байна.

2. Тайлант онд нэмэлт санхүүжилтийн 43.3 сая төгрөгийн гүйцэтгэлийн тайланг ирүүлээгүй байна.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Байхгүй болно.

4.3 Албан шаардлага

1. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)- мэдээлэл хэсэгт: 8 удаагийн гүйлгээгээр бүгд 145.1 сая төгрөгийг, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг хэсэгт 5 удаагийн гүйлгээгээр бүгд 167.1 сая төгрөгийг нийт 312.2 сая төгрөгийг шилэн дансанд байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.4, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 4.5-д заасан заалтыг зөрчсөн байна.

2. Тайлант онд 43.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хийгдсэн ч тайланг гаргаж ирүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Арвайхээр сумын Нарны дөш ӨЭМТөв	2	355.2	0	0	0	0	2	355.2		

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ц.ЧАНЦАЛДИЙМАА

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 24-НЫ ӨДӨР